



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2022.12.30 № 3/6632
танай _____-ны № _____-т

Тайлан хүргүүлэх тухай


Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/117 дугаар тушаалаар баталсан “Хууль сахиулах байгууллагуудын жендэрийн нэгдсэн бодлого” /2018-2021/-ын баримт бичгийг салбарын хэмжээнд хэрэгжүүлэн ажилласан.

“Хууль зүй, дотоод хэргийн яамны жендэрийн салбар зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тус бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт 7 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



П.САЙНЗОРИГ

**“ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН
ХҮРЭЭНИЙ ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН ЖЕНДЭРИЙН
НЭГДСЭН БОДЛОГО” (2018-2021)-ЫН ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

Үндэслэл: Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2-т “тухайн салбар, орон нутгийн хэмжээнд хүйсээр ангилсан статистикийн мэдээллийг бүрдүүлэх, жендэрийн эрх тэгш байдлын төлөв байдал, бодлогын үр нөлөөг үнэлэх” гэж, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7 дугаар заалтыг тус тус үндэслэл болгов.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/116 дугаар тушаалаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/117 дугаар тушаалаар батлагдсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний хууль сахиулах байгууллагуудын жендэрийн нэгдсэн бодлого” (2018-2021)-ын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж гаргах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллалаа. Ажлын хэсгийн ахлагчаар Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, гишүүнээр мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн, хошууч, Хил хамгаалах ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн офицер, хошууч, Дотоод хэргийн их сургуулийн ЭЗНУС-ийн Нийтийн эрх зүйн тэнхимийн дэд профессор, Ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар тус яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн нарын бүрэлдэхүүнтэй 2022 оны 11 дүгээр сарын 11-15-ны өдрүүдэд ажиллав.

Зорилго: Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/117 дугаар тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний хууль сахиулах байгууллагуудын жендэрийн нэгдсэн бодлого” (2018-2021)-ын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж гаргах.

Зохион байгуулалт: Ажлын хэсгийн гишүүдийн ажил үүргийн хуваарь гарган тухайн чиг үүргийг гүйцэтгэн нэгтгэн дүгнэж, зөвлөмж боловсруулах хэлбэрээр ажиллав.

Хамрах хүрээ: “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний хууль сахиулах байгууллагуудын жендэрийн нэгдсэн бодлого” (2018-2021)-д тусгагдсан 4 зорилтын 12 арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлсэн ажил.

**БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАСАН ЗОРИЛТ БҮРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ**

Бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг үнэлж дүгнэхдээ Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газраас ирүүлсэн 2019-2021 оны төлөвлөгөөний биелэлтэд тулгуурласан болно.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн А/117 дугаар тушаалаар баталсан “Хууль сахиулах байгууллагуудын жендэрийн нэгдсэн бодлогын баримт бичиг” дунд хугацааны хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө нь 4 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан байна.

Бодлогын баримт бичигт хийсэн үнэлгээг хүснэгтээр харуулбал:

№	Бодлогод туссан		Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь					Хувь оноо	Зорилтын дундаж үнэлгээ
	Зорилт	Он	0	30	50	70	100		
1.	Хууль зүй, дотоод хэргийн яам болон хууль сахиулах байгууллагын бүх түвшний удирдах ажилтнуудын жендэрийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, бодлого төлөвлөгөөндөө жендэрийн дүн шинжилгээ хийж, ашиглах чадавхыг дээшлүүлэх;	2019 он	-	-	-	-	1	-	67.7%
		2020 он 8 арга хэмжээ	-	4	-	1	4	65.5%	
		2021 онд 8 арга хэмжээ	-	3	-	1	4	70.0%	
2.	Хууль сахиулах салбарт ажиллаж байгаа эмэгтэй, эрэгтэй хүмүүст тэгш боломж олгосон, жендэрийн ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан аливаа хүчирхийллээс ангид байх ажлын орчин болгох;	2019 он	-	-	-	-	2	-	91.2%
		2020 онд 4 арга хэмжээ	-	-	-	1	3	92.5%	
		2021 он 6 арга хэмжээ	-	-	-	2	4	90.0%	
3.	Хууль сахиулах салбарт жендэрийн тэгш боломжийг дэмжсэн эрх зүй, бодлогын орчинг бий болгож, эмэгтэйчүүдийн оролцооны чадавхыг дээшлүүлэх;	2019 он	-	-	-	-	-	-	92.5%
		2020 онд 4 арга хэмжээ	-	-	-	-	4	100%	
		2021 онд 6 арга хэмжээ	-	-	-	3	3	85.0%	
4.	Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний чадавхыг дээшлүүлэх.	2020 онд 2 арга хэмжээ	-	-	-	1	1	85.0%	85.0%
		2021 онд 2 арга хэмжээ	-	-	-	1	1	85.0%	
Нийт дүн: 84.3 хувь (4.2 оноо)									

Зорилт бүрийн хэрэгжилтийн үр дүн:

Бодлогын баримт бичгийн зорилт бүрийн үнэлгээг харьцуулахад 1 дүгээр зорилт хамгийн бага буюу 67.7 хувь, 3.3 оноотой дүгнэгдсэн байгаа нь хууль сахиулах байгууллагуудын бодлого, төлөвлөгөө, үйл ажиллагаанд жендэрийн үнэлгээний тогтолцоог нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Өөрөөр хэлбэл, хууль сахиулах байгууллагуудын жендэрийн нэгдсэн бодлогын баримт бичгийг 2018-2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тодорхой заасан боловч жендэрийн үнэлгээний аргачлалыг боловсруулж нэвтрүүлэх, жендэрийн

мэдрэмжийг үнэлэх, хяналтын хуудас ашиглах, дүн шинжилгээ хийх ажил хийгдээгүй байна. Энэ нь байгууллагын соёл, жендэрийн мэргэжилтний идэвх оролцооноос шууд хамаарч байна. Харин хууль сахиулах салбарын бүх түвшний удирдах ажилтнуудад жендэрийн шаталсан сургалтыг Дотоод хэргийн их сургууль дотооддоо болон харьяа байгууллагуудын хүсэлтээр зохион байгуулсан нь эерэг үр авчирсан байна.

Бодлогын баримт бичгийн 2 болон 3 дугаар зорилтын хүрээнд хийгдсэн ажлууд нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон Засгийн 2017 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/117 дугаар тушаалаар батлагдсан “Хууль сахиулах байгууллагуудын жендэрийн нэгдсэн бодлогын баримт бичиг”-ийн үндсэн үзэл баримтлал болох жендэрийн эрх тэгш байдал, жендэрт суурилсан аливаа хүчирхийллээс ангид байх ажлын орчин бий болгох чиглэлд “тодорхой үр дүн”-д хүрч ажилласан байна.

2021 онд тус яамны харьяа агентлаг, байгууллагуудын хөдөлмөрийн дотоод журамд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4.1-д заасныг тусган мөрдүүлж байгаа эсэхэд дүн шинжилгээг “Эрдэм сургалт судалгааны хүрээлэн” НҮТББ хийж, дүнг салбарын хэмжээнд танилцуулж, “Ажлын байрны бэлгийн дарамт” сэдэвт сургалтыг 1011 (эрэгтэй-617, эмэгтэй-394) алба хаагчдад зохион байгуулсан нь үр дүнтэй арга хэмжээ болсон байна.

Хууль сахиулах байгууллагууд нь өдөр тутмын хөдөлмөрийн харилцаа, ажиллах нөхцөлийг зохицуулсан хөдөлмөрийн дотоод журамдаа жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх, жендэрийн тэгш байдлыг хангах, аливаа хэлбэрийн дарамт шахалтад орвол гомдол гаргах эрх, үүргийн талаар нэмэлт, өөрчлөлт оруулан хэрэгжүүлж байна.

Мөн Дотоод хэргийн их сургуулийн бакалавр болон магистрын түвшний сургалтад элсэгчдийн хүйсийн харьцаанд квот тогтоож, эмэгтэйчүүдийн элсэлтийн хувийг нэмэгдүүлэхэд анхаарч ажилласан байна.

Цаашид хууль сахиулах салбарт жендэрийн тэгш боломжийг дэмжсэн, эмэгтэйчүүдийн оролцооны чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн зорилт, арга хэмжээний тоо, цар хүрээг нэмэгдүүлэх нь зүйтэй байна.

Төлөвлөгөөний хэрэгжилтээс 70 хувьтай үнэлэгдсэн 10, 30 хувьтай үнэлэгдсэн 3 арга хэмжээ тус тус байна.

30 хувьтай хэрэгжүүлсэн арга хэмжээний тухайд:

-4.2.2.Оролцоонд суурилсан жендэрийн үнэлгээг сонгогдсон 2 байгууллагад хийх;

-4.2.3.2020 онд үнэлгээ хийх байгууллагад бэлтгэл зохион байгуулалтыг хийж сургалт хийх;

-4.3.1.Жендэрийн шалгуур үзүүлэлт, хяналтын хуудсыг сонгосон байгууллагад туршин сайжруулах гэсэн арга хэмжээнүүд хамаарч байна.

Гүйцэтгэл нь тодорхой хэмжээнд гарсан боловч үр дүнд хүрээгүй дараах арга хэмжээ байна. Үүнд:

-4.3.2.Хууль зүй, дотоод хэргийн яамны жендэрийн салбар зөвлөлөөс жендэрийн дүн шинжилгээний үр дүнд суурилсан хүний нөөцийн бодлого хөтөлбөр,

түүний хэрэгжилтийг жендэрийн мэдрэмжтэй болгох удирдамж боловсруулах (2020 он);

-4.4.1.Илүү уртасгасан цагаар ажиллах нөхцөл байдал үүссэн тохиолдолд ажилтан, албан хаагчдын ажил-амьдралын тэнцвэрийг хадгалах зохицуулалтын механизмыг бий болгох (2020 он);

-4.6.1.Ажлын орчин нөхцөл, хангамжийг эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаатай байдал, онцлог хэрэгцээнд нийцэж байгаа эсэхэд байгууллага бүр үнэлгээ хийх (2020 он);

-4.7.3.Эмэгтэй ажилтнуудыг жирэмсэн байх болон бага насны хүүхдээ асрах хугацаанд үндсэн ажлаа гүйцэтгэхэд хүндрэлтэй байвал өөр ажилд шилжүүлэн ажиллуулах, энэ хугацааны цолны нэмэгдэлийг бүх байгууллага төсөвтөө суулган олгож байхыг баталгаажуулсан зохицуулалтыг хийх (2021 он);

-4.9.1.Эмэгтэйчүүдийг тусгайлан чадавхжуулах сургалтуудыг үе шаттай зохион байгуулах (2021 он);

-4.9.2.Хууль сахиулах байгууллагын удирдах ажилтан эмэгтэйчүүдийн клуб байгуулах (2021 он);

-4.10.2.Салбарын эрдэм шинжилгээний хурлуудад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, ялгаварлан гадуурхлыг арилгах асуудлаар илтгэл оруулах (2021 он).

Дүгнэлт: Хууль сахиулах байгууллагуудын жендэрийн нэгдсэн бодлогын баримт бичгийн (2018-2021 он) хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ **84.3** хувь буюу **4.2** оноотой **“Тодорхой үр дүнд хүрсэн”** байна.

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЯВЦАД ГАРСАН ХҮНДРЭЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН НӨХЦӨЛИЙГ ҮНЭЛЭХ

“Хууль сахиулах байгууллагуудын жендэрийн нэгдсэн бодлогын баримт бичгийг (2018-2021 он) хэрэгжүүлэх явцад гарсан хүндрэл, түүний шалтгаан, нөхцөлийг үнэлэх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар үнэлгээ, дүгнэлт, санал боловсруулав. Үүнд:

30 хувьтай арга хэмжээний тухайд: Салбарын бодлогын баримт бичгийг нийт агентлаг, байгууллагуудад сурталчлах, мэдээлэл өгөх, таниулах, хэрэгжүүлэх алба, нэгжийг тусгайлан зааж өгөөгүй, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, тайланг нэгтгэх, түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй ирүүлсэн байна. Мөн дэвшүүлсэн 4 зорилтын хүрээнд хийсэн ажил, арга хэмжээний тайлан, биелэлтийг зарим байгууллагууд ирүүлээгүй байна.

Хууль зүй, дотоод хэргийн яам болон салбар зөвлөлөөс оролцоонд суурилсан үнэлгээг хийх 2 байгууллагыг сонгосон боловч нарийн төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлээгүй, үнэлгээ хийх саналын хуудсыг эхний байдлаар боловсруулсан төдий байна.

Мөн коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын улмаас зарим төлөвлөсөн ажил, арга хэмжээ удаашрах, тасалдах, хууль сахиулах байгууллагын нийт алба хаагчид өндөржүүлсэн бэлэн байдалд үүрэг гүйцэтгэн ажиллаж байсан

нь нөлөөлсөн. Хөл хорионы үед гэр бүлийн хүчирхийллийн тоо эрс ихэссэн бөгөөд цагдаагийн байгууллагаас таслан зогсоох арга хэмжээг авч, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон цахим орчинд нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэн ажилласан.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний хууль сахиулах байгууллагуудын жендэрийн нэгдсэн бодлого нь 2018 оны 6 дугаар сард батлагдсан бөгөөд тус бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв тухайн онд тусгагдаагүй байсан, мөн харьяа агентлаг, байгууллагуудад жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн томилогдоогүй, алба хаагчид жендэрийн шаталсан сургалтад хамрагдаж чадавхжаагүй байсантай холбогдуулан 2018 онд хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн зарим арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Гүйцэтгэл нь “тодорхой үр дүнд хүрсэн” зорилтын тухайд: Байгууллагын удирдах ажилтны жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтөөс хамаарч хүний нөөцийн бодлого, томилгоо, сэлгэн ажиллуулах, хүүхэд асрах чөлөөтэй байх хугацааны цолны нэмэгдэл зэрэг асуудлыг хүний нөөцийн бодлогын баримт бичигт тусгаж ажиллах шаардлагатай. Түүнчлэн, чөлөөт цагаар өөрийгөө хөгжүүлэх клуб, дугуйлан байгуулах, хамрагдах тал дээр байгууллагын захиргаанаас дэмжлэг бага үзүүлсэн байна.

Салбарын эрдэм шинжилгээний хурлуудад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, ялгаварлан гадуурхлыг арилгах асуудлыг Цагдаагийн ерөнхий газар, Дотоод хэргийн их сургуулиас бусад байгууллагуудад хангалттай хэмжээнд зохион байгуулагдаагүйг анхаарах нь зүйтэй.

ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ ЗӨВЛӨМЖ

“Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний хууль сахиулах байгууллагуудын жендэрийн нэгдсэн бодлого”-д хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээнд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Төрийн захиргааны удирдлагын газарт:

1.Жендэрийн үндэсний хорооны 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031)”-ний хэрэгжилтийг салбарын хэмжээнд мэргэжил, арга зүйгээр ханган зохион байгуулж ажиллах;

2.Салбарын жендэрийн нэгдсэн бодлогын баримт бичгийг бодлого, төлөвлөлтийн нэгдмэл байдлыг хангаж стратеги болон бусад бодлогын баримт бичигтэй уялдуулан, зорилт, шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, хүрэх түвшин, үр дүнг тооцон боловсруулж, 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор батлуулах;

3.Бодлогын баримт бичиг болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулахдаа тус яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар болон харьяа агентлаг, байгууллагын төлөвлөлт хариуцсан албан хаагчдын оролцоог хангах;

4.Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”, 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу байгууллагын бодлого, төлөвлөлтийн нэгдмэл байдал, уялдаа, холбоог хангаж төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулан хэрэгжилтийг ханган, тайланг чанартай ирүүлэх, нотлох баримтыг тогтмол хавсаргах, бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй арга хэмжээний шалтгааныг нотломжид үндэслэн тайлагнах;

5.Хууль зүй, дотоод хэргийн яам болон харьяа агентлаг, байгууллагын ажиллагсдын хүйсийн тэнцвэрт байдлын мэдээ, яам, харьяа агентлаг, байгууллагын дэргэдэх Хороо, Зөвлөл, Комиссын бүрэлдэхүүний хүйсийн тэнцвэрт байдлын мэдээг нэгтгэн гаргах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, үр дүн (З-ЖЭТБ-2)-ийн тайланг Үндэсний статистикийн хорооноос баталсан маягт, зааврын дагуу программд оруулж, мэдээллийн санг бүрдүүлэх;

6.“Жендэрийн салбар зөвлөл”-ийн хуралдааныг жилд 2-оос доошгүй удаа тогтмол хуралдуулж, төлөвлөгөөнд тусгагдсан ажлын биелэлтийг тогтмол хянах, хэрэгжилт зогссон болон хэрэгжилт хангалтгүй ажлыг эрчимжүүлэх;

7.Жендэрийн бодлого, хөтөлбөрт тусгагдсан төсөв, хөрөнгө шаардсан зорилт, арга хэмжээг тодорхойлж, тооцоо судалгаа гарган шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлж, хэрэгжилтийг хангах, тайланд санхүүжилтийг тайлагнах;

8.Өөрийн байгууллагын бодлого, хөтөлбөртөө нийцүүлэн, ажилтан, алба хаагчдын хүний нөөцийн асуудлыг оновчтой тодорхойлох, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээнд тохирсон, ялгаварлан гадуурхалтгүй ажиллах орчинг бүрдүүлэх чиглэлд анхаарч ажиллах;

9.Жендэрийн нэгдсэн бодлогод дэвшүүлсэн зорилтуудын хүрээнд хууль сахиулах байгууллагуудын жигд оролцоог хангах, түүнд тавих хяналтыг сайжруулах;

10.Аливаа бодлого, хөтөлбөр, төслийг төлөвлөх, хэрэгжүүлэхэд жендэрийн эрх тэгш байдлын үзэл баримтлалыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийж, жендэрийн мэдрэмжтэй бодлого, шийдвэрийг тусгуулахад анхаарч ажиллах.

Харьяа агентлаг, байгууллагад:

1.Жендэрийн үндэсний хорооны 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031)”-ний хэрэгжилтийг ханган ажиллах;

2.Бодлого, төлөвлөлтийн нэгдмэл байдлыг хангаж стратеги болон бусад бодлогын баримт бичигтэй уялдуулан, зорилт, шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, хүрэх түвшин, үр дүнг тооцсон төлөвлөгөөг (төлөвлөгөөг боловсруулахдаа хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж, харьяа алба, нэгжийн төлөвлөлт хариуцсан албан хаагчдын оролцоог хангах) хэрэгжүүлэх;

3.Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”, 217 дугаар

тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу байгууллагын бодлого төлөвлөлтийн нэгдмэл байдал, уялдаа, холбоог хангаж төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулан хэрэгжилтийг ханган, тайланг чанартай ирүүлэх, нотлох баримтыг тогтмол хавсаргах, бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй арга хэмжээний шалтгааныг нотломжид үндэслэн тайлагнах;

4.Байгууллагад ажиллагсдын хүйсийн тэнцвэрт байдлын мэдээ болон байгууллагын дэргэдэх Хороо, Зөвлөл, Комиссын бүрэлдэхүүний хүйсийн тэнцвэрт байдлын мэдээг үнэн зөв, тогтмол гаргаж ирүүлэх, бүртгэл судалгааны санг бүрдүүлэх;

5.“Жендэрийн дэд салбар зөвлөл”-ийн хуралдааныг жилд 2-оос доошгүй удаа тогтмол хуралдуулж, төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилтийг тогтмол хянах, хэрэгжилт зогссон болон хэрэгжилт хангалтгүй ажлыг эрчимжүүлэх;

6.Жендэрийн бодлого, хөтөлбөрт тусгагдсан төсөв, хөрөнгө шаардсан зорилт, арга хэмжээг тодорхойлж, тооцоо судалгаа гарган шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлж, хэрэгжилтийг хангах, тайланд санхүүжилтийг тайлагнах;

7.Байгууллагын төсвийн тодотголд жендэрийн дэд салбар зөвлөлийн үйл ажиллагааны төсвийг тусгаж, жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтний хавсран гүйцэтгэх урамшууллыг шийдвэрлэх;

8.Өөрийн байгууллагын бодлого, хөтөлбөртөө нийцүүлэн, ажилтан, алба хаагчдын хүний нөөцийн асуудлыг оновчтой тодорхойлох, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээнд тохирсон, ялгаварлан гадуурхалтгүй ажиллах орчинг бүрдүүлэх чиглэлд анхаарч ажиллах;

9.Аливаа бодлого, хөтөлбөр, төслийг төлөвлөх, хэрэгжүүлэхэд жендэрийн эрх тэгш байдлын үзэл баримтлалыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийж, жендэрийн мэдрэмжтэй бодлого, шийдвэрийг тусгуулахад анхаарч ажиллах зэрэг болно.

---oOo---